



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**Даланзадгад  
2023 он**

# ӨМНӨГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

## **1. Бодлогын зорилтыг хангах талаар**

- 1.1. Удирдлага зохион байгуулалт
- 1.2. Тайлан мэдээ, албан бичиг
- 1.3. Санхүү, үнэт цаасны тооцоо, тайлан мэдээ

## **2. Иргэний улсын бүртгэл**

- 2.1. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл, шилжилт хөдөлгөөний бүртгэл
- 2.2. Гадаадад зорчих эрхийн бүртгэл
- 2.3. Иргэний үнэмлэх олгох ажил
- 2.4. Иргэний бүртгэлийн архивийн лавлагаа, тайлан мэдээ

## **3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл**

3.1. Иргэн, хуулийн этгээдийн өмчлөх эрхийн бүртгэл, өөрчлөлт, түүнтэй холбоотой бусад эрхийн бүртгэл, лавлагаа, тайлан мэдээ

3.2. Иргэний газар өмчлөх эрхийн улсын бүртгэл

3.3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх мэдээллийн сан, нотлох баримтаар хувийн хэрэг бүрдүүлж, иргэн, хуулийн этгээд болон хууль хяналтын байгууллагыг лавлагаа, мэдээллээр хангах чиглэлээр

## **4. Хуулийн этгээдийн улсын бүртгэл**

- 4.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэл, лавлагаа, тайлан мэдээ

## **5. Програм хангамжийн талаар**

## **6. Улсын бүртгэлийн хяналт шалгалт**

- 6.1 Хяналт шалгалт - Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр
- 6.2 Хяналт шалгалт - Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр
- 6.3 Хяналт шалгалт - Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр
- 6.4 Бусад ажил, үйлчилгээ

## **7. Удирдлагын багт тавих санал**

## **БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХАНГАХ ТАЛААР**

### **1.1 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР**

Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь УБЕГазрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24 ны өдрийн Б/424 тоот тушаалаар 34 орон батлагдсанаас 2023 оны эхний хагас жилд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 1, Хяналтын улсын байцаагч 1, Тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 2, Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 4, Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 14, архивч 2, Ахлах нягтлан бодогч 1, Мэдээллийн технологийн ажилтан 1, Бичиг хэргийн эрхлэгч 1, гэрээт албан хаагч үйлчлэгч 2, жижүүр 2, нийт 31 албан хаагчтайгаар Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон орон нутгийн удирдлагаас өгсөн үүрэг, даалгавар, удирдамж, чиглэл, тушаал, бодлогын баримт бичиг, холбогдох бусад хууль, журам, Засгийн газрын болон аймаг, сумын ИТХурлын тогтоолийг тухай бүр хяналтанд авч бүртгэж, өдөр тутмын ажил, үйлчилгээнд бүрэн хэрэгжүүлж, иргэн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг орон нутагт эрхлэн зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн Улсын бүртгэлийн үйлчилгээг үнэн зөв, ил тод, түргэн шуурхай, шударга, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэн ажиллаж байна.

## **МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ.**

➤ 2022 оны 12 дугаар сарын 14-24 ны өдрүүдэд Өмнөговь аймгийн ЗДТГазар, АНУлсын Хойд Америкийн их сургуультай хамтран АНУлсын Вашингтон хотод зохион байгуулсан “Төслийн менежментийн манлайлал”, “Удирдлагын манлайлал” сэдэвт танхимын сургалтанд хэлтсийн дарга Ч.Энхмөнх оролцсон.

➤ 2023 оны 01 дүгээр сарын 30 ны өдрөөс 02 дугаар сарын 04 ны өдрүүдэд УБЕГазар, БНСУлсын Менежментийн нийгэмлэгийн хамтран зохион байгуулсан “Хүртээмжтэй манлайлал-Эерэг хамт олон бүрдүүлэх нь” сэдэвт сургалтанд оролцсон.

➤ 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас “E-doc Албан хэрэг хөтлөлт”-ийн программын онлайн сургалтад Бичиг хэргийн эрхлэгч О.Жижигчулуун оролцсон.

➤ 2023 оны 01 дүгээр сарын 06 ны өдөр ГХБХБГазраас зохион байгуулсан “Газрын багц хууль”-ийн танхимын сургалтанд ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал, ХЭУБүртгэгч М.Энхтогтох нар оролцсон.

➤ 2023 оны 01 дүгээр сарын 17 ны өдөр “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлого” нэгдсэн хэлэлцүүлэгт хэлтсийн 15 албан хаагч оролцож, “Нээлттэй Өмнөговь” төслийн танилцуулгад хэлтсийн дарга Ч.Энхмөнх Иргэний шилжин суурьших хөдөлгөөний бүртгэл, мэдээллийн талаар мэдээлэл хийсэн.

➤ 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын шуурхай цахим хуралд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх оролцсон.

➤ 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр АНУ-ын ЭСЯ-ын дипломат аюулгүй байдлын албанаас зохион байгуулсан онлайн сургалтад Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Ариунсайхан, ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал, ХУБайцаагч Д.Наранбилэг нар оролцсон.

➤ 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Өмнөговь аймгийн Татварын хэлтсээс “Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт” сэдэвт танхимын сургалтанд хэлтсийн 15 албан хаагч суусан.

➤ 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр “Төрийн сангийн удирдлагын цахим систем” сэдэвт танхимын сургалтанд хэлтсийн дарга Ч.Энхмөнх, Ахлах нягтлан бодогч С.Батхүү нар суусан.

➤ 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуралд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Ариунсайхан, ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал нар оролцсон.

➤ 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуралд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх оролцсон.

➤ 2023 оны 01 дүгээр сарын 27 ны өдөр Улаанбаатар хотод Өмнөговь аймгийн төсвийн орлогын бааз, суурийг нэмэгдүүлэх, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг бодит үнэлэх зорилгоор зохион байгуулсан “Нээлттэй Өмнөговь-Хариуцлагатай татвар төлөгч” зөвлөгөөнийг аймгийн ЗДТГазрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс хамтран зохион байгуулж, ажлын хэсэгт хэлтсийн дарга Ч.Энхмөнх, ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал, Мэдээллийн технологийн ажилтан О.Эрдэнэбат нар ажиллаж мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. Зөвлөгөөнд Өмнөговь аймагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг үндсэн 17 компани, тэдгээрийн туслаг гүйцэтгэгч 256 компанийн 780 албан тушаалтан, төлөөлөл оролцсон.

➤ 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуралд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх оролцсон.

➤ 2023 оны 01 дүгээр сарын 30 ны өдрөөс 2 сарын 05 ны өдрүүдэд БНСУлсын Сүүл хотод зохион байгуулсан “Хүртээмжтэй манлайлал-Эерэг хамт олон бүрдүүлэх нь” сэдэвт 3 өдрийн танхимын сургалтанд хэлтсийн дарга Ч.Энхмөнх, Ахлах нягтлан бодогч С.Батхүү, ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал, Ханбогд сумын улсын бүртгэгч У.Цэенням нар суралцаж, төрийн албаны чиглэлээр туршлага судалж ирсэн.

➤ 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр аймгийн ХХААГазраас Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр бизнес эрхлэгчидэд зориулсан сургалтанд хэлтсийн дарга Ч.Энхмөнх, ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал, ХУБайцаагч Д.Наранбилэг нар мэдээлэл өгсөн.

➤ 2023 оны 02 дугаар сарын 14-ны өдөр УБЕГазрын цахим хуралд хэлтсийн дарга Ч.Энхмөнх оролцсон.

➤ 2023 оны 02 дугаар сарын 24-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас “Гадаад паспортын программын тухай” цахим хуралд Иргэний улсын бүртгэгч нар оролцсон.

➤ 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуралд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх оролцсон.

➤ 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын шуурхай хуралд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх оролцсон.

➤ 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын шуурхай хуралд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх оролцсон.

➤ 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Энхийн хүслэн эрүүл мэндийн төвөөс зохион байгуулсан “Нүд-Гэр бүлийн харилцаа” сэдэвт танхимын сургалтад хэлтсийн 12 албан хаагч суусан.

➤ 2023 оны 03 дугаар сарын 02—ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг “Арга зүйн” 12 удаагийн сургалтанд албан хаагчдыг бүрэн хамруулсан.

➤ 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр аймгийн ЗДТГазар, НҮБ-ийн Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас хамтран зохион байгуулсан сургалтанд хэлтсийн дарга Ч.Энхмөнх мэдээлэл өгсөн.

➤ 2023 оны 03 дугаар сарын 17 ны өдөр УБЕГазарт зохион байгуулагдсан Удирдах ажилтаны зөвлөгөөнд хэлтсийн дарга Ч.Энхмөнх суусан.

➤ 2023 оны 03 дугаар сарын 17 ны өдөр Өмнөговь аймагт зохион байгуулагдсан “Нээлттэй Өмнөговь-Хариуцлагатай татвар төлөгч” сургалт, зөвлөгөөнд ЭХЭУБТасгийн дарга бөгөөд Улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал мэдээлэл өгсөн.

➤ 2023 оны 03 дугаар сарын 20 ны өдөр хэлтсийн дарга Ч.Энхмөнх хэлтсийн албан хаагчдад танхимаар, сумдын улсын бүртгэгч нарын онлайнаар оролцуулж УБЕГазрын удирдах ажилтаны зөвлөгөөний талаар мэдээлэл өгч, сургалт зохион байгуулсан.

➤ 2023 оны 03 дугаар сарын 21-23-нд АЗДТГазар, Удирдлагын академитай хамтран зохион байгуулсан “Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат шинэ сэргэлтийн бодлого” сэдэвт танхимын сургалтанд хамрагдаж сертификаттай төгссөн.

➤ 2023 оны 03 дугаар сарын 21 ны өдөр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын албан хаагчид, Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчидын уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

➤ 2023 оны 03 дугаар сарын 23 ны өдөр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас зохион байгуулагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарт зориулсан онлайн сургалтанд хамрагдсан.

➤ 2023 оны 03 дугаар сарын 27 ны өдөр аймгийн Монгол банкны ажилтан Ургамалцэцэг, Болд нар хэлтсийн 13 албан хаагчид “Зээлийн сан”-гийн талаар сургалт зохион байгуулсан.

➤ 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас “Амьдрах урлаг ба иога, бясалгал” сэдэвт онлайн сургалтанд хэлтсийн нийт албан хаагчид оролцсон.

➤ 2023 оны 03 дугаар сарын 28-нд Монгол банкнаас зохион байгуулсан “Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа” сэдэвт танхимын сургалтанд оролцсон.

➤ 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газраас “Нөхөн бүртгэлтэй холбоотой” онлайн сургалтанд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Ариунсайхан, ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал, ХУБайцаагч Д.Наранбилэг, ХЭУБүртгэгч М.Энхтогтох нар оролцсон.

➤ 2023 оны 03 дугаар сарын 30-31 ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан баг Гашуун сухайт боомтод нээгдсэн “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д хэлтсийн дарга Ч.Энхмөнх, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Ариунсайхан, ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал нар ажиллаж сургалт зохион байгуулсан.

➤ 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын өргөтгөсөн шуурхай хуралд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх оролцсон.

➤ 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зориулсан онлайн сургалтанд ЭХЭУБТасгийн бүртгэгч нар оролцсон.

➤ 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр Өмнөговь аймгийн Насан туршийн боловсролын төвөөс “Ухаалаг цахим хэрэглээ” сэдэвт танхимын сургалтанд хэлтсийн 12 албан хаагч суусан.

➤ 2023 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр Өмнөговь аймгийн Цагдаагийн газраас “Ажлаас халшрах хам шинж” сэдэвт танхимын сургалтанд хэлтсийн 14 албан хаагч суусан.

➤ Улсын бүртгэлийн хэлтсийн нийт албан хаагчид 2023 оны 04 дүгээр сараас 2023 оны 05 дугаар сарын 18-ны хооронд Улсын тэргүүний 4 дүгээр сургуулийн мэргэжлийн багш нараар 7 хоног бүрийн 2 дахь өдөр болон 4 дэх өдөр хэлтсийн 2 давхрын сургалтын танхимд нэг удаагийн хичээл 60 минутаар 10 удаа буюу 10 цагийн монгол бичгийн анхан болон дунд шатны хичээлийг заалгаж судалсан.

➤ 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас “Эрүүл мэндийн даатгал ашиглалтын тухай” онлайн сургалтанд хэлтсийн нийт албан хаагчид оролцсон.

➤ 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр ХЗДХэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзоригоор ахлуулсан ажлын хэсгийн зохион байгуулсан Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлэгт хэлтсийн 15 албан хаагч оролцсон.

➤ 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр ЦЕГазрын Хар тамхитай тэмцэх хэлтсээс зохион байгуулсан “Та бол үр хүүхдийнхээ хамгаалагч, халамжлагч” сэдэвт танхимын сургалтанд хэлтсийн 10 халбан хаагч суусан.

➤ 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр аймгийн Прокурорын газраас зохион байгуулсан Зөрчилийн тухай хуулийн цахим сургалтанд хэлтсийн дарга Ч.Энхмөнх, Хяналтын улсын байцаагч Д.Наранбилэг нар оролцсон.

➤ 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүү, Аж ахуйн хэлтсээс зохион байгуулсан “Санхүүчдийн сургалт, зөвлөгөөн”-д Ахлах нягтлан бодогч С.Батхүү оролцсон.

➤ 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр аймгийн ЗДТГазраас зохион байгуулсан “Нээлттэй Өмнөговь-Иргэн таны боломж” өдөрлөгт хэлтсийн дарга Ч.Энхмөнх мэдээлэл өгсөн.

➤ 2023 оны 04 дүгээр сарын 25-нд Ханбогд сумын Прокурорын газраас зохион байгуулсан цахим сургалтанд хамрагдсан.



➤ 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуралд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх оролцсон.

➤ 2023 оны 05 дугаар сарын 01-ны өдөр Сангийн яамнаас зохион байгуулсан “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем” сэдэвт танхимын сургалтанд хэлтсийн дарга Ч.Энхмөнх, ахлах нягтлан бодогч С.Батхүү нар суусан.

➤ 2023 оны 05 дугаар сарын 02-нд УБЕГазрын Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан цахим сургалтанд хамрагдсан.

➤ 2023 оны 05 дугаар сарын 02-ны аймгийн ЗДТГазар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, Улсын бүртгэлийн хэлтсээс хамтран зохион байгуулсан “Дэлхийн гэр бүлийн өдөрт зориулсан өдөрлөгт хэлтсийн дарга Ч.Энхмөнх мэдээлэл өгсөн.

➤ 2023 оны 05 дугаар сарын 03-ны УБЕГазрын цахим хуралд хэлтсийн дарга Ч.Энхмөнх оролцсон.

➤ 2023 оны 05 дугаар сарын 10-ны УБЕГазрын даргын зөвлөлийн тавдугаар хуралд хэлтсийн дарга Ч.Энхмөнх цахимаар оролцсон.

➤ 2023 оны 05 дугаар сарын 17-20 ны өдрүүдэд Терроризмтой тэмцэх зөвлөлөөс Өмнөговь аймагт зохион байгуулсан “Хаан шонхор 2023” дадлага, сургалтанд хэлтсийн дарга Ч.Энхмөнх, улсын бүртгэгч Т.Нямсамбуу, З.Хасар нар оролцож, хувиарлагдсан багт үүрэг гүйцэтгэсэн.

➤ 2023 оны 05 дугаар сарын 17-19 ны өдрүүдэд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан “Ажлын байранд дадлагажуулах” танхимын сургалтанд ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Ариунсайхан оролцсон.

➤ 2023 оны 05 дугаар сарын 24-ны өдөр Татварын хэлтэстэй хамтран аймгийн татварын байцаагч нарт ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч М.Энхтогтох нар сургалт зохион байгуулсан.

➤ 2023 оны 05 дугаар сарын 24-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газар, И-Монголиа академи, Архивын ерөнхий газраас “Цахим гарын үсэг, Тоон гарын үсгийн тухай” онлайн сургалтанд нийт албан хаагчдыг хамруулсан.

➤ 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр ЗГХЭГазраас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагыг бэхжүүлэх нь” сэдэвт цахим хэлэлцүүлэгт хэлтсийн албан хаагчид бүрэн оролцсон.

➤ 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас шинээр томилогдсон албан хаагчдад “Ажлын байранд бэлтгэх анхан шатны сургалт”-д УЛсын бүртгэлийн хэлтсийн Баяндалай сумын улсын бүртгэгч А.Цэрэндолгорыг хамруулсан.

➤ 2023 оны 06 дугаар сарын 07-09 ны өдрүүдэд ОБЕГГазраас Өмнөговь аймагт зохион байгуулсан гамшиг, ослын үеийн бэлэн байдлын “Стратегийн команд штабын сургалт”-нд “Иргэний бүртгэл мэдээллийн мэргэжлийн анги” бүрэн оролцсон.

➤ 2023 оны 06 дугаар сарын 14 ний өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан Итгэмжлэгдсэн ажилтануудад зориулсан чиглэл өгөх сургалтад Ноён сумын улсын бүртгэгч У.Нандинцэцэг, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Ариунсайхан, Хяналтын улсын байцаагч Д.Наранбилэг, МТАжилтан Х.Хулан нар хамрагдав.

➤ 2023 оны 06 дугаар сарын 16 ны өдөр Хэлтсийн дарга Ч.Энхмөнх “УБЕГ-ын ажлын ачааллыг хянах” программын тухай цахим сургалт, мэдээлэл өгсөн.

➤ 2023 оны 06 дугаар сарын 21 ний өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” цахим сургалтад нийт албан хаагчид хамрагдав.

➤ 2023 оны 06 дугаар сарын 20 ны өдөр “Анар систем ХХК”-аас ДОСХ системийн сургалтад Бичиг хэргийн эрхлэгч О.Жижигчулуун хамрагдав.

➤ Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрийн 110 дах заалт “Хөгжлийн гүүр” дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн 21 агентлагын дарга нарын хамт 2023 оны 06 дугаар сарын 20-25 ны өдрүүдэд БНХАУлсын Шанхай, Бээжин хотод соёлын аялал, Хөх хотын Аж үйлдвэрийн их сургуульд “Удирдлагын манлайлал”-ын танхимын сургалтанд хамрагдаж, хэлтсийн 15 албан хаагчдад мэдээлэл өгсөн.

➤ 2023 оны 08 дугаар сарын 15 ны өдөр, 10 дугаар сарын 30 ны өдрүүдэд аймгийн ХААГазар, Вест сургалтын төвөөс хамтран зохион байгуулсан 2 удаагийн “Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч нарт зориулсан сургалт”-нд Хяналтын улсын

байцаагч Д.Наранбилэг, ХЭ,ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч М.Энхтогтох нар Улсын бүртгэлийн чиглэлээр мэдээлэл өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

➤ 2023 оны 09 дүгээр сарын 08 ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан “Их өгөгдөл ашиглан дүн шинжилгээ хийх” сургалтад ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Ариунсайхан, ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал нар хамрагдав.

➤ 2023 оны 09 дүгээр сарын 21 ний өдөр Академич С.Нарангэрэл багшийн “Хүмүүн байхын утга учир ёс суртахуунд оршвой” сэдэвт сургалтад хэлтсийн 10 албан хаагч сумдын улсын бүртгэгч нар цахимаар хамрагдав.

➤ 2023 оны 10 дугаар сарын 02 ны өдөр Сонгуулийн ерөнхий хорооноос зохион байгуулсан “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт”-ийн талаарх танхимын сургалтанд Хэлтсийн дарга, Хяналтын улсын байцаагч, ИУБТасгийн дарга нар суусан.

➤ 2023 оны 10 дугаар сарын 04 ний өдөр Даланзадгад сумын ЗДТГазраас зохион байгуулсан “Хөдөлмөрын аюулгүй байдал, эрүүл ахуйн” сургалтад Иргэний улсын бүртгэгч Б.Баясгалан, Ахлах нягтлан бодогч С.Батхүү, Бичиг хэргийн эрхлэгч О.Жижигчулуун нар оролцов.

➤ 2023 оны 10 дүгээр сарын 04 ний өдөр Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс “Цахим хөгжил, цахим шилжилт” сэдэвт сургалтад хэлтийн 15 албан хаагч оролцов.

➤ 2023 оны 10 дугаар сарын 13 ны өдөр Хэлтсийн дарга Ч.Энхмөнх “ТАХ-ын ёс зүйн тухай хууль”-ийг сурталчлан таниулж хэлтсийн нийт албан хаагчдад сургалт, мэдээлэл өгсөн.

➤ 2023 оны 10 дугаар сарын 19 ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс “Төрийн албан хаагч ба дипломат ёслол” сэдэвт сургалтанд нийт албан хаагч оролцов.

➤ 2023 оны 10 дугаар сарын 19 ны өдөр Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Эрчүүд ба эрүүл мэнд” сэдэвт сургалтад Ахлах нягтлан бодогч С.Батхүү, Улсын бүртгэгч Т.Нямсамбуу, Улсын бүртгэгч З.Хасар, Жижүүр Б.Гандөш, Д.Болдбаатар нар оролцов.

➤ 2023 оны 10 дугаар сарын 23 ны өдөр АЗДТГазраас зохион байгуулсан “Хүний нөөцийн хөгжил” сэдэвт сургалтад Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, Бичиг хэргийн эрхлэгч О.Жижигчулуун нар хамрагдав.

➤ 2023 оны 10 дугаар сарын 23 ны өдөр аймгийн ЗДТГазар, ИРД олон улсын мэргэжлийн хөгжлийн институтын хамтран зохион байгуулсан “Чадварлаг Монгол хүн-Үндэсний брэнд” сэдэвт танхимын сургалтанд хэлтсийн 14 албан хаагч суусан.

➤ 2023 оны 10 дугаар сарын 25 ны өдөр Нийгмийн даатгалын хэлтсээс “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн танилцуулгад Ахлах нягтлан бодогч С.Батхүү, Бичиг хэргийн эрхлэгч О.Жижигчулуун нар хамрагдав.

➤ 2023 оны 10 дугаар сарын 25 ны өдөр УБЕГ-аас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээ” сэдэвт цахим сургалтад Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, Бичиг хэргийн эрхлэгч О.Жижигчулуун, Хяналтын улсын байцаагч Д.Наранбилэг, Хуулийн этгээдийн бүртгэгч М.Энхтогтох, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Ариунсайхан нар хамрагдав.

➤ 2023 оны 10 дугаар сарын 25 ны өдөр УБЕГ-аас зохион байгуулсан “Сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулга” сургалтад Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Ариунсайхан нар хамрагдав.

➤ 2023 оны 10 дугаар сарын 25 ны өдөр УБЕГ-аас зохион байгуулсан “ХБИргэдэд үйлчлэх үйлчилгээг хүртээмж болгох” сэдэвт сургалтад нийт албан хаагчид хамрагдав.

➤ 2023 оны 09 дүгээр сарын 10 ны өдрөөс 25 ны өдрүүдэд УБЕГ, Койка олон улсын хамтын ажиллагааны агентлагаас хамтран БНСУлсын Сөүл хотод Солонгосын Дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн албан хаагчдын сургалтын төвд зохион байгуулсан “Монгол улсын бүртгэлийн тогтолцооны чадавхийг бэхжүүлэх нь” сэдэвт танхимын сургалтанд хэлтсийн дарга Ч.Энхмөнх суралцаж, туршлага судалж ирсэн.

➤ 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх үйлчилгээг хүртээмжтэй болгох” сэдэвт сургалтад Бичиг хэргийн эрхлэгч О.Жижигчулуун, Хяналтын улсын байцаагч Д.Наранбилэг, Хуулийн этгээдийн бүртгэгч М.Энхтогтох, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Ариунсайхан нар хамрагдав.

➤ 2023 оны 10 дугаар сарын 26 ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс “Аз жаргалтай ажилтан” сэдэвт сургалтад нийт албан хаагч оролцов.

➤ 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр JCI Mongolia академийн сургагч багш Б.Төрзаяа “Хувь хүний хөгжлийг дэмжих амьдрах ухааны чадварыг дээшлүүлэх” сэдэвт цахим сургалтад нийт албан хаагчид хамрагдав.

➤ 2023 оны 10 дугаар сарын 31 ний өдөр Төрийн албаны зөвлөлийн нарийн бичгийн дарга С.Баярнасан “ТАХ-ын ёс зүйн тухай хууль”-ийг сурталчлан таниулж хэлтсийн нийт албан хаагчдад сургалт, мэдээлэл өгсөн.

➤ 2023 оны 11 дүгээр сарын 01-нд “Хөгжлийн шийдэл”ТББ-с бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулж зохион байгуулсан танхимын сургалтанд ЭХЭУБүртгэлийн талаар Хяналтын улсын байцаагч Д.Наранбилэг мэдээлэл хүргэсэн.

➤ 2023 оны 11 дүгээр сарын 03 ны өдөр Тагнуулын ерөнхий газраас зохион байгуулсан “Кибер аюулгүй байдлын тухай хууль”-ийг сурталчлах, танилцуулга сургалтад Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, Бичиг хэргийн эрхлэгч О.Жижигчулуун, МТАжилтан Х.Хулан нар оролцов.

➤ 2023 оны 11 дүгээр сарын 09 ны өдөр Төрийн албаны зөвлөлөөс “Амжилтад хүрэх хүсэл” сэдэвт сургалтанд нийт албан хаагч оролцов.

➤ 2023 оны 11 дүгээр сарын 09 ны өдөр Төв номын сангаас “Тусч уншигч” ээжүүдийн сургалтад Улсын бүртгэгч Б.Баясгалан оролцов.

➤ 2023 оны 11 дүгээр сарын 10-нд УБЕГ-н Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан “Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд ажиллах журам”-н танилцуулга сургалтанд нийт албан хаагчдыг хамруулсан.

➤ 2023 оны 11 дүгээр сарын 22 ны өдөр УБЕГ-аас Сумдын улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр мэргэшүүлэх, ажлын байранд бэлтгэх сургалтад 10 бүртгэгчийг хамруулсан.

➤

### **ЦАГ ҮЕИЙН АЖИЛ**

➤ 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 91.74%тай үнэлүүлж улсад 2-р байрт шалгарсан.

➤ 2023 оны 02 сард Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Өмнөговь аймгийн Засаг даргатай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 90.7%тай үнэлүүлж “Тэргүүний хамт олон” болсон.

- 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс call center үйлчилгээнд нэгдэж хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн.
- 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс Улсын бүртгэлийн үйлчилгээнд Капитрон банкны Посс машин хоёрыг ашиглаж эхэлсэн.
- 2023 оны 03 дугаар сарын 13,16-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн хэлтсийн 20 албан хаагчыг 2 ээлжээр Улаанбаатар хотод П.Шастины нэрэмжит 3 дугаар эмнэлэгт “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн багц шинжилгээ, үзлэг”-т бүрэн хамруулсан. Өмнөговь аймгаас Улаанбаатар хот явах, ирэх унааны зардал 1.200.000 төгрөгийг хэлтсийн ҮЭХороо бүрэн шийдвэрлэсэн.
- 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс шинэчлэгдэн батлагдсан үндэсний энгийн болон цахим гадаад паспортын захиалга авч эхэлсэн.
- 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийн тухай цаг үеийн мэдээ мэдээллийг Улсын бүртгэлийн хэлтсийн вэб сайтадаар дамжуулж Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Энхмөнх иргэдэд мэдээлэл хүргэсэн.
- 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөр, Аймгийн Засаг даргын “Нутгийн хишиг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “ЦАГ ГАРГАЯ” биеийн тамирын арга хэмжээний нээлтэнд байгууллага хамт олноороо идэвхитэй оролцсон. Аяны удирдамжийн дагуу төлөвлөгөө гаргаж батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- 2023 оны 04 дүгээр сарын 20-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, аймгийн Засаг дарга Р.Сэддорж болон удирдлагын баг Улсын бүртгэлийн хэлтсийн ажил, үйлчилгээтэй танилцсан.
- 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Энхмөнх албан хаагчдаас ажлын байр, багийн ажиллагааны талаар сэтгэл ханамжийн санал асуулгыг боловсруулж 14 албан хаагчдаас 14 асуулгаар судалгааг авч, дүнг албан хаагчдад танилцуулсан.
- 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр УИХурлын гишүүн Н.Наранбаатараар ахлуулсан ажлын хэсгийн зохион байгуулсан "Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлэг"-т албан хаагчид оролцсон.
- 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр хэлтсийн ойр орчмын 50м<sup>2</sup> газрын хог хаягдлыг цэвэрлэсэн.

➤ 2023 оны 05 дугаар сарын 24-ны өдөр Аймгийн Татварын газарт татварын улсын байцаагч нарыг чадваржуулах нэгдсэн сургаланд хуулийн этгээд, ЭХЭУБүртгэлийн хууль, журам, улсын бүртгэлээс хасагдах хуулийн этгээд, ЭХЭУБүртгэлийн талаар мэдээлэл хийж хамтран ажилласан.

➤ 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдөр "Хүүхдэд ээлтэй Өмнөговь" нээлттэй өдөрлөгт Ажнай талбай дээр ажиллаж 120 хүүхдийн гадаад паспортын захиалга авч ажиллав. Мөн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын хүүхдүүдийн дунд "Ээжийн тухай дуу"-ны уралдаан зохион байгуулж, хэлтсийн ҮЭХорооноос уралдаанд оролцсон хүүхдүүдийг шагнаж урамшуулсан.

➤ 2023 оны 06 дугаар сарын 07 ны өдөр Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан “Стратегийн команд штабын сургалт”-нд Хэлтсийн дарга, Ахлах нягтлан бодогч нар оролцсон.

➤ 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2022 оны Төрийн болон орон нутгийн өмчийн гэрээг дүгнэж Улсын бүртгэлийн хэлтэс 95% буюу хангалттай дүгнэгдсэн.

➤ 2023 оны 06 дугаар сарын 08 ны өдөр Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, дадлага, сургуулалтад Улсын бүртгэлийн хэлтэс гамшгаас хамгаалаах бэлэн байдалд оролцсон.

➤ 2023 оны 06 дугаар сарын 09 ний өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлигын эсрэг нэгдье” аянд Улсын бүртгэлийн хэлтэс нэгдэж цахим хуудсаар дамжуулан авлигын эсрэг үйл ажиллагааг сургалчилан ажилласан.

➤ 2023 оны 11 дүгээрсарын 03 ны өдөр Тагнуулын ерөнхий газар, АЗДТГазартай хамтран Мэдээллийн аюулгүй байдлын газраас Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийж мэдээллийн аюулгүй байдлыг хангах сургалтад Улсынбүртгэлийн хэлтсийн дарга Ч.Энхмөнх, Мэдээллийн технологийн ажилтан Х.Хулан, Бичиг хэргийн эрхлэгч О.Жижигчулуун нар оролцсон.

➤ 2023 оны 11 дүгээр сарын 16-19 ны өдрүүдэд УБЕГазарт зохион байгуулагдсан спортын арга хэмжээнд Төвийн бүс / Дархан-Уул, Сэлэнгэ, Дундговь, Төв, Өмнөговь/ амжилттай оролцож “Шилжин явах цом” авсан.

➤ Өмнөговь аймгийг 2020-2024 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн 15 сумын “Нутгийн дэм” хөтөлбөрт хамрагдаж байгаа төсөвт байгууллагуудын 2600 төрийн

албан хаагчдын оршин суугаа хаягийн мэдээллийг нягтлан шалгах ажлыг хийж гүйцэтгэсэн.

➤ Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрийн 110 дах заалт “Хөгжлийн гүүр” дэд хөтөлбөрийн хүрээнд Улсын бүртгэлийн хэлтэст 3 ба түүнээс дээш жил тогтвор суурьшилтай, амжилттай ажиллаж байгаа 24 албан хаагчийн зардлыг аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 16 ны өдрийн А/2110 тоот захирамжаар шийдвэрлэж 2023 оны 11 дүгээр сарын 20-25 ны өдрүүдэд БНХАУлсын Жининь, Бээжин, Хөх хотод соёлын аялалд хамруулсан.

### **АЙМАГ, ОРОН НУТГИЙН УДИРДЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖИЛ:**

➤ 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр “Нээлтэй Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх аймгийн ЗДТГазрын Олон нийттэй харилцах алба болон Алтан говь телевизд шилжин ирэх иргэдэд зориулсан цаг үеийн болон хууль, журмын талаар мэдээлэл өгсөн.

➤ 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Даланзадгад сумын ЗДТГазар, ИТХуралтай хамтран Өмнөговь аймгийн ИТХурлын 2022.12.01 ны 9/9 дугаартай тогтоолын хэрэгжилтийн хүрээнд “ Даланзадгад суманд шинээр байгуулагдсан 9 дүгээр баг /Чандмань/, 10 дугаар баг /Начин/-тай холбоотой иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэл, баримт бичиг солих” ажлыг хэрхэн зохион байгуулах талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.

➤ УБЕГазар, Тогтвортой хөгжлийн хөтөч НҮТББ, БНСУлсын Менежментийн нийгэмлэгээс хамтран зохион байгуулсан албан хаагчдын чадавхижуулах, туршлага судлах сургалт, арга хэмжээнд 4 албан хаагчын зардалыг “Хөгжлийн гүүр” хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн ИТХурлын дарга Б.Бадраа, аймгийн Засаг дарга Р.Сэддорж, Ханбогд сумын Засаг дарга Х. Нэхийт нар бүрэн шийдвэрлэсэн.

➤ 2023 оны 02 сарын 04-05 ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 1, 3, 4 дүгээр багуудын Иргэдийн нийтийн хуралд оролцож нийт 370 иргэнд Улсын бүртгэлийн талаар цаг үеийн мэдээлэл өгч тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулсан.



➤ Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 16 ны өдрийн А/1843 захирамжаар Улсын бүртгэлийн хэлтсийн цахилгааныг иж бүрэн шинэчлэх ажлын зардалыг 49 150 600 төгрөгөөр шийдвэрлэсэн дагуу 2022 оны 12 дугаар сарын 18 ны өдрөөс 2023 оны 02 дугаар сарын 18 ны өдөр хүртэл хугацаатай ӨМАОНӨГ/202209332 гэрээний дугаартай “Повеополарис” ХХК бүрэн гүйцэтгэж, аймгийн ЗДТГазрын даргын 2023 оны 02 дугаар сарын 13 ны өдрийн А/235 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажлыг хүлээн авсан.

➤ 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд ажиллаж 140 иргэнд тоон гарын үсэг олгосон.

➤ Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 23 ны өдрийн А/930 тоот захирамжийн дагуу 2023.02.07-14 ны өдрийн хооронд Сэврэй сумын улсын бүртгэгч С.Мөнхбаяр, Баяндалай сумын улсын бүртгэгч А.Цэрэндолгор нар Дундговь аймгийн Гурвансайхан суманд байрлах отрын штабт ажиллаж тухайн орон нутагт отроор өвөлжиж, хаваржиж байгаа малчдад Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.

➤ 2023.03.30-31-ны өдрүүдэд Ханбогд сумын Хайрхан баг, Гашуун Сухайт боомт, Цагаан хад суурьшлын бүс дэх ХУРДАН төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн нээлт, Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрийн хүрээнд “Явуулын оффис” үйлчилгээгээр ЭХЭУБ, ИУБүртгэлийн 100 гаруй гадаад паспорт, 30 гаруй иргэний үнэмлэхний захиалга авч, 160 иргэнд "Тоон гарын үсэг" олгож, 21 иргэнд ЭХЭУБүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн.

➤ 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр хэлтсийн дарга Ч.Энхмөнх Үндэсний энгийн цахим гадаад паспортын талаар Өмнөговь аймгийн ЗДТГазрын Олон нийттэй харилцах алба болон Алтан говь телевизд мэдээлэл өгсөн.

➤ 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны "Нутгийн хишиг" хөтөлбөрийн хүрээнд "Явуулын оффис" -оор Ханбогд сумын Хайрхан баг, Цагаан хад суурьшлын бүсэд Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээгээр 150 иргэнд үйлчилсэн.

➤ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 11 ний өдрийн шуурхай хуралдаанаар өгсөн үүрэг даалгаврын дагуу 2022 оны 01 дүгээр сарын 01 ний өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 31 ний өдрийг хүртлэх хугацаанд Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын

бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч З.Хасар, Ч.Пүрэвдавга, Гурвантэс сумын улсын бүртгэгч Ч.Батхүү, Цогтцэций сумын улсын бүртгэгч Б.Буянжаргал, Ханбогд сумын улсын бүртгэгч Ц.Цэенням нарын бүртгэсэн нийт 2778 иргэний гадаад паспортын бүртгэлийн мэдээллийг нягтлан шалгаж илтгэх хуудсыг холбогдох газарт хүргүүлсэн.

➤ 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр аймгийн Биеийн тамир, спортын газартай хамтран бие бялдрын сорилд хэлтсийн 14 албан хаагчдыг хамруулсан.

➤ 2023.04.27-28 ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Нээлттэй Өмнөговь-Иргэн таны боломж” өдөрлөгт оролцож нийт 500 гаруй иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч 260 иргэнд гадаад паспорт, иргэний үнэмлэх, тоон гарын үсэг олгож, 80 иргэнд ЭХЭУБүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн.

➤ 2023 оны 04 дүгээр сарын 28 нд Улсын бүртгэлийн алба хаагчид байгууллагын гаднах талбайн цэцэрлэгжүүлэлтийг нөхөн сэргээж, 30 агч, 30 голт бор, 35 шар хуайс шинээр тарьсан.

➤ 2023 оны 05 дугаар сарын 05 ны өдөр аймгийн Онцгой байдлын газарт “Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээ”-г зохион байгуулж 65 иргэнд гадаад паспорт, шилжилт хөдөлгөөн, иргэний үнэмлэх, тоон гарын үсэг олгосон.

➤ 2023 соны 05 дугаар сарын 06-ны өдөр Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны "Нутгийн хишиг" мөрийн хөтөлбөрийн хүрээнд Цогтцэций суманд Улсын бүртгэлийн "Явуулын оффис"-оор 220 иргэнд үйлчилсэн.

➤ 2023 соны 05 дугаар сарын 12-ны өдөр Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны "Нутгийн хишиг" мөрийн хөтөлбөрийн хүрээнд Цагаан хад суурьшлын бүсийн Төрийн үйлчилгээний нэдсэн төвд "Явуулын оффис"-оор ажиллаж 125 иргэнд үйлчилсэн.

➤ 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Өмнөговь аймгийн Засаг даргын А/727 тоот захирамжын дагуу Даланзадгад сумаас Цогт-Овоо сум хүртэлх автозамын 88-90 км хүртэлх хуваарьт газрын хогийг цэвэрлэсэн.

➤ 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Аймгийн Өмнөговь аймгийн Засаг даргын "Нутгийн хишиг" хөтөлбөрийн хүрээнд Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан аймгийн Засаг даргын тамгийн газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран "Нээлттэй Өмнөговь - Гэр бүлийн чуулган"-ыг зохион байгуулсан.

➤ Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “НУТГИЙН ХИШИГ” ХӨТӨЛБӨР, “ЯВУУЛЫН ОФФИС”-оор 2023 оны 05 дугаар сарын 12 ны өдөр Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хад суурьшлын бүсэд Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээг үзүүлж 100 гаруй иргэнд гадаад паспорт, 5 иргэнд улсын бүртгэлийн лавлагаа олгож хаяж үрэгдүүлсэн болон хугацааны сунгалт хийлгэсэн 7 иргэний цахим үнэмлэхний захиалга авч тараах ажлыг зохион байгуулсан, 40 иргэнд “Тоон гарын үсэг” олгосон.

➤ Өмнөговь аймгийн Засаг даргын “Нутгийн хишиг” хөтөлбөрийн хүрээнд Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан аймгий Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран 2023 оны 05 дугаар сарын 15 ны өдөр “Нээлттэй Өмнөговь-Гэр бүлийн чуулган”-ыг зохион байгуулж гэрлэлтээ батлуулсан 22 хосуудад гэрлэлтийн гэрчилгээг гардуулсан.

➤ 2023 оны 05 дугаар сарын 23 ны өдөр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харъяа Өмнөговь аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хоригдож байгаа 3 иргэний цахим үнэмлэхний захиалга авч, 24 албан хаагчдад тоон гарын үсэг олгосон.

➤ 2023 оны 4,5,6 саруудад ХААН банктай хамтран ХААН банкны тооны төвүүдэд “Тоон гарын үсэг”-ийг нийт 3314 иргэнд олгосон.

➤ Өмнөговь аймгийн ИТХурлын 2022.12.01-ний өдрийн 9/9 тогтоолоор Даланзадгад сумын 1 дүгээр баг хуваагдаж 9 дүгээр баг “Чандмань”, 6 дугаар баг хуваагдаж 10 дугаар баг “Начин” шинээр байгуулагдсан. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 2023.06.10 ны өдрийн 11-16 цагт аймгийн ЗДТГазар, ГХБХБГазар, Улсын бүртгэлийн хэлтэс хамтран Спорт цогцолборын “Ёл” танхим, ХЖТеатрт тус тус төрийн үйлчилгээний “Явуулын оффис” үйлчилгээг зохион байгуулж 122 иргэний газар үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг шинээр сольж олгон, 80 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл, 63 иргэний иргэний үнэмлэхний захиалга авч үйлчилсэн.

➤ Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “НУТГИЙН ХИШИГ” ХӨТӨЛБӨР, “ЯВУУЛЫН ОФФИС”-оор 2023 оны 06 дугаар сарын 26 ны өдөр Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хад суурьшлын бүсэд Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээг үзүүлж 73 иргэнд гадаад паспорт, 15 иргэнд улсын бүртгэлийн лавлагаа олгож хаяж үрэгдүүлсэн болон хугацааны

сунгалт хийлгэсэн 3 иргэний цахим үнэмлэхний захиалга авч, 110 иргэнд “Тоон гарын үсэг” олгосон.

➤ 2023 оны 07 дугаар сарын 06 ны өдөр Өмнөговь аймгийн Ханхонгор суманд нэг цэгийн үйлчилгээ зохион байгуулж тус өдөрлөгөөр 35 иргэнд гадаад паспорт, 21 иргэнд улсын бүртгэлийн лавлагаа олгож хаяж үрэгдүүлсэн болон хугацааны сунгалт хийлгэсэн 12 иргэний цахим үнэмлэхний захиалга авч, 158 иргэнд “Тоон гарын үсэг” олгосон.

➤ Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлэх, иргэдэд тоон гарын үсгийн талаарх ойлголтыг өгөх, мэдээлэл хүргэх зорилгоор ХААН банктай хамтран 2023 оны 09 дүгээр сарын 08 ны өдөр Ханхонгор сум, 09 дүгээр сарын 15 ны өдөр Номгон сум, 09 дүгээр сарын 22 ны өдөр Хүрмэн сум, 09 дүгээр сарын 18-22 ны өдрүүдэд Цогтцэций сумдын ХААН банкны тооны төвүүдэд 633 иргэнд тоон гарын үсэг олгосон.

➤ Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “НУТГИЙН ХИШИГ” ХӨТӨЛБӨР, “ЯВУУЛЫН ОФФИС”-оор 2023 оны 09 дүгээр сарын 20-23 ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Манлай сумын Далай, Өехий, Өгөөмөр, Жаргалант багуудад Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээ зохион байгуулж 235 иргэнд гадаад паспорт, иргэний үнэмлэх, тоон гарын үсэг олгож нийт 450 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.

➤ Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “НУТГИЙН ХИШИГ” ХӨТӨЛБӨР, “ЯВУУЛЫН ОФФИС”-оор 2023 оны 10 дугаар сарын 12-13 ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Манлай суманд Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээ зохион байгуулж 178 иргэнд гадаад паспорт, иргэний үнэмлэх, тоон гарын үсэг олгож нийт 320 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгсөн.

➤ 2023 оны 10 дугаар сарын 28 ны өдөр “Дэвшилтэт Даланзадгад” хөтөлбөрийн хүрээнд Даланзадгад сумын иргэдэд төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх “Хөдөлгөөнт баг” арга хэмжээнд оролцож 260 гаруй иргэдэд гадаад паспортын захиалга, иргэний үнэмлэхний захиалга, шилжилт хөдөлгөөний бүртгэл хийж тоон гарын үсэг олгож 380 гаруй иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн.

➤ 2023.10.31-ны өдөр Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга С.Баярнасан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн сургалтыг зохион байгуулж хэлтсийн нийт албан хаагчдыг хамруулсан.

➤ Өмнөговь аймгийг 2020-2024 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрийн хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 04 ний өдөр зохион байгуулагдсан нэг цэгийн үйлчилгээнд оролцож 40 гаруй иргэнд тоон гарын үсэг олгож зөвлөгөө мэдээлэл өгсөн.

➤ Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “НУТГИЙН ХИШИГ” ХӨТӨЛБӨР, “ЯВУУЛЫН ОФФИС”-оор 2023 оны 11 дүгээр сарын 16 ны өдөр Өмнөговь аймгийн Хүрмэн сум, 2023 оны 11 дүгээр сарын 24 ны өдөр Баяндалай сумдуудад Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээ зохион байгуулж иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл, иргэний үнэмлэхний бүртгэл нийт 32 бүртгэл, 60 гаруй иргэнд тоон гарын үсэг олгож мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.

➤ Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрийн 110 дах заалт “Хөгжлийн гүүр” дэд хөтөлбөрийн хүрээнд Улсын бүртгэлийн хэлтэст 3 ба түүнээс дээш жил тогтвор суурьшилтай, амжилттай ажиллаж байгаа 24 албан хаагчийн зардлыг аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 16 ны өдрийн А/2110 тоот захирамжаар шийдвэрлэж 2023 оны 11 дүгээр сарын 20-25 ны өдрүүдэд БНХАУлсын Жининь, Бээжин, Хөх хотод соёлын аялалд хамруулсан.

### **БОЛОВСОН ХҮЧНИЙ ТАЛААР:**

Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 1, Хяналтын улсын байцаагч 1, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 2, Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 4, иргэний улсын бүртгэлийн улсын бүртгэгч 14, архивч 2, ахлах нягтлан бодогч 1, мэдээллийн технологийн ажилтан 1, Бичиг хэргийн эрхлэгч, нярав 1, гэрээт албан хаагч үйлчлэгч 2, жижүүр 2, 31 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

➤ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 27 ны өдрийн Б/123 дугаар тушаалаар А.Цэрэндолгорыг Баяндалай сумын улсын бүртгэгчээр томилов.

➤ Хэлтсийн даргын 2023 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн Б/06 дугаар тушаалаар Ш.Уранчимэгийг хэлтсийн үйлчлэгчийн үүрэгт ажилд томилов.

- Хэлтсийн даргын 2023 оны 04 дүгээр сарын 07 ны өдрийн Б/09 дугаар тушаалаар Ч.Бямбасүрэнг Мэдээллийн технологийн үүрэг ажлаас чөлөөлөв.
- Хэлтсийн даргын 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Б/10 дугаар тушаалаар Х.Хуланг Мэдээллийн технологийн ажилтаны үүрэгт ажилд томилов.
- Хэлтсийн даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Б/12 дугаар тушаалаар Ц.Насанбаярыг хэлтсийн үйлчлэгчийн үүрэгт ажлаас чөлөөлөв.
- Хэлтсийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн Б/13 дугаар тушаалаар С.Цэцэгдэлгэрийг хэлтсийн үйлчлэгчийн үүрэгт ажилд томилов.
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 21 ний өдрийн Б/479 дугаар тушаалаар Ч.Пүрэвдавгыг иргэний улсын бүртгэгчээс чөлөөлж ЭХЭУБТасгийн Хуулийн этгээдийн улсын бүртгэгчээр томилов.
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 17 ны өдрийн Б/566 дугаар тушаалаар Д.Насантуяаг ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн үүрэгт ажлаас чөлөөлөв.
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 01 ний өдрийн Б/593 дугаар тушаалаар ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийг түр орлон гүйцэтгэгч С.Ариунсайханг үүрэгт ажлаас чөлөөлж, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн үүрэгт ажилд томилов.
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 10 дүгээр сарын 27 ны өдрийн Б/695 дугаар тушаалаар Б.Азжаргалыг ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн үүрэгт ажлаас чөлөөлөв.
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 23 ны өдрийн Б/683 дугаар тушаалаар Б.Баттулгыг Иргэний улсын бүртгэгчийн үүрэгт ажилд томилов.
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 10 ны өдрийн Б/738 дугаар тушаалаар С.Мөнхбаярыг Иргэний улсын бүртгэгчийн ажлаас чөлөөлж, ЭХЭУБТасгийн Эд хөрөнгийн улсын бүртгэгчээр томилов.
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 10 ны өдрийн Б/737 дугаар тушаалаар Т.Нямсамбууг ЭХЭУБТасгийн Эд хөрөнгийн улсын бүртгэгчийн үүрэгт ажлаас чөлөөлж, Иргэний улсын улсын бүртгэгчийн үүрэгт ажилд томилов.
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 20 ны өдрийн Б/753 дугаар тушаалаар М.Энхтогтохыг ХЭ,ЭХЭУБТасгийн Хуулийн

этгээдийн улсын бүртгэгчийн үүрэгт ажлаас чөлөөлж, ХЭ,ЭХЭУБТасгийн ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн үүрэгт ажилд томилов.

➤ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 22 ны өдрийн Б/759 дугаар тушаалаар З.Хасарыг Иргэний улсын бүртгэлийн тасгийн иргэний улсын бүртгэгчийн үүрэгт ажлаас чөлөөлөлж Гадаадын иргэн, харьяатын газарт шилжүүлэв.

### **ТАЙЛАН МЭДЭЭ, АЛБАН БИЧГИЙН ТАЛААР:**

2023 оны жилийн эцсийн байдлаар Улсын бүртгэлийн хэлтэст 794 албан бичиг ирсэнийг зохих журмын дагуу бүртгэн авч холбогдох ажилтнуудад шилжүүлэн, биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа. 592 хариутай албан бичиг ирснээс хариуг тухай бүрт нь шийдвэрлүүлэн холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдэд хүргэж ажилласан.

Улсын бүртгэлийн хэлтэст 2023 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс нийт 67 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирсэнийг холбогдох албан тушаалтанд шилжүүлэн, иргэдэд хариуг өгч, шийдвэрлэлтэнд хяналт тавьж, ажилласан.

### **1. САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

2. **Төсвийн зарцуулалт:** 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд УБЕГ газрын Санхүү, төлөвлөлтийн газарт хүргүүлэн ажилласан.

Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүр холбогдох тодруулгын хамт Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүү, төлөвлөлтийн газарт хугацаанд нь хүргүүлсэн.

2023 оны үйлчилгээний орлогын төлөвлөгөө 250 000 000 /Хоёр зуун тавин сая/ төгрөг. Үүнээс 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 224 088 195,4 /Хоёр зуун хоёр дөрвөн сая наян найман мянга нэг зуун ерин таван төгрөг дөрвөн мөнгө/ төвлөрүүлсэн.

2023 оны 02 дугаар сарын 24-ний өдөр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Хаан консалтинг ХХК-аар шалгуулж “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн мэдээллийг сар бүрийн 7-ны өдрийн дотор жилийн

хэмжээнд 163 мэдээлэл оруулахаас 163 удаа шилэн дансны мэдээллийг бүрэн гаргаж байршуулсан.

**3. Үйлчилгээний хураамж, үйл ажиллагааны орлого:** Иргэний бүртгэлийн үйлчилгээний хураамж 210000089483 тоот дансанд, эд хөрөнгийн үйлчилгээний хураамж 210000093088 тоот дансанд, цахим үнэмлэхний үнэ 210000258471 тоот дансанд тус тус тушаалган Өмнөговь аймгийн Төрийн сангийн 100110012008 тоот дансанд төвлөрүүлэн, улмаар сар бүрийн 25-ны дотор Улсын төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна.

**Бараа материал, үндсэн хөрөнгө:** Иргэний бүртгэлийн 21 төрөл, Эд хөрөнгийн бүртгэлийн 3 төрөл, Хуулийн этгээдийн 3 нийт 27 төрлийн үнэт цаас ашиглагдаж байгааг УБЕГазраас хөрөнгийн санхүүжилтээр авч нөөцийг бүрэн ханган ажиллаж байна.

2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2022 оны Төрийн болон орон нутгийн өмчийн гэрээг дүгнэж Улсын бүртгэлийн хэлтэс 95% буюу хангалттай дүгнэгдсэн.

## **2. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛ**

### **НЭГ. БОДЛОГЫН ЗӨВЛӨГӨӨГӨӨР ХАНГАХ**

Тайлангийн хугацаанд Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын талаарх тоон мэдээг сар бүр нэгтгэн гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газарт тогтмол хүргүүлэн ажиллаа.

Сумдын улсын бүртгэгч нарын сарын мэдээ, тайланг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж байх, улсын бүртгэлийн мэдээллийн санд регистрийн дугаар буруу, овог, нэр, үсгийн зөрүүтэй иргэдийн зөрчлийг тухай бүр арилгаж дуусгах чиглэл өгч ажиллаж байна. Тухайлбал:

- ✓ Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр 36 иргэний төрсний бүртгэл, гэрлэсний бүртгэл, хурууны хээ зөрсөн бүртгэл, үрчилсний бүртгэлийг тус тус нөхөж мэдээллийн санд оруулсан.
- ✓ Мэдээллийн санд үсгийн алдаатай болон мэдээлэл буруу орсон 108 иргэний мэдээллийн алдааг засуулахаар тухай бүр нь Иргэний улсын



бүртгэлийн газарт албан бичэг, нотлох баримтын хамт хүргүүлж зөрчлийг арилгасан. Мөн иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч нарт нөхөн бүртгэл, нэмэлт өөрчлөлтийн эрх өгсөний дагуу мэдээллийн санд 96 иргэний мэдээллийг засварласан.

Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасаг 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 24 –ны өдрийг хүртлэх хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022.01.06-ны өдрийн 4/134 тоот чиглэлийн дагуу 2023 онд 26482 бүртгэлийн 36145 хуудас бүрдүүлбэрийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд цахимжуулсан.
2. Өмнөговь аймгийн харъяат 100 ба түүнээс дээш насны иргэдийн мэдээллийг иргэний бүртгэлийн мэдээллийн санд шалгаж, багийн Засаг дарга нараас тодруулан илтгэх хуудсыг холбогдох газарт хүргүүлсэн.
3. Аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Улсын ахлах бүртгэгч нарт зориулсан “Иргэний үнэмлэхийн зураг засварын програм ашиглах, заавал анхаарах асуудлын талаар чиглэл өгөх сургалт”-аар өгсөн үүрэг даалгаварын дагуу 2023 оны 01 дүгээр сарын 20 ны өдөр зураг тулгалтын программд 72 иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн зураг тулгалтыг хийж илтгэх хуудсыг холбогдох газарт хүргүүлсэн.
4. 2023 оны 01 дүгээр сард 15 сумын 2022 оны иргэний улсын бүртгэлийн бүрдүүлбэр материалыг татан авч хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч нартай хамтран шалгаж иргэний улсын бүртгэлийн архивт хүлээлгэн өгсөн.
5. Улсын бүртгэлийн хэлтсийн нэг давхарын үйлчилгээний танхимд мини фото зургийн стүдтэй болж мэргэжлийн зурагчин Ж.Амартүвшингээс зургийн чанар стандарт, гэрэлтүүлгийн талаар зөвлөгөө авч гадаад паспортын зургийн чанар стандартыг дээшлүүлэн ажиллаж байна.
6. Аймаг , нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сонгуулийн хэсэг байгуулж, нутаг дэвсгэрийг, зарласан тухай Өмнөговь аймгийн Ноён сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн тогтоолын эх хувийн мэдээллийг шалгаж [election.gasr.mn](http://election.gasr.mn) хаягт бүртгэн оруулж 2023 оны 03 дугаар сарын 10 өдрийн 2/184 тоот албан бичгээр Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн. Мөн санал авах байрны хаягыг нэмж оруулсан.

7. Улсын бүртгэлийн тухай хууль, журмыг сурталчилан танилцуулах, Улсын бүртгэлийн цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх, иргэдэд мэдлэг, дадлага олгох, чадавхижуулах сургалтыг зохион байгуулж, иргэдийн сэтгэл ханамжийн дүгнэлтэнд үндэслэн цаашдын сургалтын хэрэгцээг тодорхойлох, Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор сумдын улсын бүртгэгч нараас Улсын бүртгэлийн тухай хууль, журам, улсын бүртгэлийн цахим үйлчилгээний талаархи мэдээлэл, сурталчилгаа хийх ажлын төлөвлөгөө боловсруулан авч хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
8. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үндэслэн үйлдэх бөгөөд түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүртгэх, эдгээртэй холбоотой гомдлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Ноён сумын 2 дугаар багийн 14-8-2 дахь хэсгийн 408 сонгогчийн хэсэг оноолтыг election.gasr.mn Иргэний улсын бүртгэлийн системд нягтлан шалгаж илтгэх хуудсыг холбогдох газарт хүргүүлсэн.
9. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” А/829 тоот тушаал, Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 2023 оны 04 дүгээр сарын 18 ны өдрийн чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж холбогдох газарт илтгэх хуудсыг хүргүүлсэн.
10. Нэмэлт, өөрчлөлтийн бүртгэлтэй холбоотой Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналтын улсын ахлах байцаагчийн 2023 оны 04 дүгээр сарын 13 ны өдрийн 48 дугаар албан шаардлага ирүүлсэний дагуу хариу тайлбарыг холбогдох газарт хүргүүлсэн.
11. Улсын бүртгэлийн хэлтсийн даргын өгсөн үүрэг даалгаварын дагуу сумдын улсын бүртгэгчид улсын бүртгэлийн тухай хууль, журмыг сурталчлан танилцуулах, улсын бүртгэлийн цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор иргэдэд мэдлэг олгох сургалтын төлөвлөгөө боловсруулан

батлуулсан бөгөөд төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан сургалтын тайланг авч нэгтгэсэн.

12. Иргэний улсын бүртгэлийн тасгийн архивт байрлах хаатр, маягт, бүрдүүлбэр материал цэгцлэх ажлын төлөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу иргэний улсын бүртгэлийн тасгийн архивт байрлах нас барсан иргэдийн хувийн хэрэгт байршаагүй 353 ширхэг ХААТР-15 ИУБ-15, ХААТР-16, ИУБ-16, ХААТР-21, ИУБ-31 магтыг хувийн хэрэгт байршуулах, 2012-2022 он хүртэлх иргэний цахим үнэмлэхний бүрдүүлбэр, 2022 оны 8 төрлийн бүртгэлийн бүрдүүлбэр нийт 254 ботийг бүртгэж хайрцаглан архивт байршуулах, 1951-1989 оны 188 ширхэг бүртгэлийн журнал, 1990-2022 оны нийт 710 ширхэг бүртгэлийн журналыг бүртгэлжүүлж хайрцаглан архивт байршуулах ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн.
13. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт заасны дагуу холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн Өмнөговь аймгийн Ноён сумын 2 дугаар багийн 14-8-2 дахь хэсгийн 408 сонгогчийн нэрийн жагсаалтад хийгдсэн нэмэлт тэмдэглэгээ нягтлан шалгаж илтгэх хуудсыг холбогдох газарт хүргүүлсэн.
14. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журмын 20 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий 408 сонгогчийн хэсэг оноолтыг 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар <http://election.gasr.mn> системд нягтлан шалгаж илтгэх хуудсыг холбогдох газарт хүргүүлсэн.
15. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйл, 20.9 дэх хэсэгт заасны дагуу Өмнөговь аймгийн Ноён сумын 2 дугаар баг 14-8-2 дугаар хэсгийн хорооны сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, сонгогчдын нэрийн жагсаалтыг сонгуулийн хэсгийн хороонд хүргэх ажлыг зохион байгуулж илтгэх хуудсыг холбогдох газарт хүргүүлсэн.

16. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуулийн технологийн сургалтыг 2023 оны 06 дугаар сарын 14 ны өдөр 09.00-15.00 цагийн хооронд хэлтсийн сургалтын танхимд хэлтсийн дарга Ч.Энхмөнх, хяналтын улсын байцаагч Д.Наранбилэг, тагнуулын ахлах ажилтан Г.Даваадалай, ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Ариунсайхан, итгэмжлэгдсэн ажилтан улсын бүртгэгч У.Нандинцэцэг, мэдээллийн технологийн ажилтан, нярав Х.Хулан нарын бүрэлдэхүүнтэй 100 хувийн ирцтэй зохион байгуулж илтгэх хуудсыг холбогдох газарт хүргүүлсэн.
17. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийг 2023 оны 06 дугаар сарын 18-ний өдөр амжилттай зохион байгуулж илтгэх хуудсыг холбогдох газарт хүргүүлсэн.
18. Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран ерөнхий боловсролын 22 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 31 цэцэрлэгийн багш ажилчид, сурагчдад Улсын бүртгэлийн үйл ажиллагаа, хууль журмыг танилцуулах, тоон гарын үсэг олгох, Улсын бүртгэлийн цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор мэдлэг олгох сургалтыг зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулан хамтран ажиллаж байна.
19. Улсын бүртгэгч нарын 2023 оны 01 дүгээр сарын 02 ны өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 25 ны хооронд Улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд олгосон лавлагааг журнал болон лавлагааны жагсаалттай нэг бүрчлэн нягтлан шалгаж илтгэх хуудсыг авч ажиллаа.
20. Иргэний улсын бүртгэлийн “Мэдээллийн сан цэгцлэх” ажлын хүрээнд Өмнөговь аймагт бүртгэгдсэн 19 иргэний мэдээллийг архивын цаасан суурьт эх нотлох баримт болон цахим санд нэг бүрчлэн нягтлан шалгасан. Үүнд:
  - 17 иргэний төрсний нөхөн бүртгэл шалгахад 16 нь баталгаажсан төлөвтэй байх бөгөөд баталгаажсан мэдээлэл нь архивын цаасан суурьт эх нотлох баримт болон цахим сантай таарч байна. Цахимжаагүй нотлох баримтыг цахимжуулсан.
  - Цогтын Батбаяр /кй910910121/-ын үрчилсний нөхөн бүртгэл шалгахад баталгаажсан мэдээлэл архивын цаасан суурьт эх нотлох баримт болон цахим сантай таарч байна. Нөхөн шивэлт гэсэн төлөвтэй бүртгэл нь бүртгэсэн он, сар, өдөр архивын цаасан суурьт эх нотлох баримттай зөрүүтэй

байгаа тул уг бүртгэлийг хүчингүй болгохоор хяналтын улсын байцаагчийн 2023 оны 10 дугаар сарын 05 ны өдрийн 5944 тоот дүгнэлтийг Иргэний улсын бүртгэлийн газарт 2023 оны 10 дугаар сарын 10 ны өдрийн 02/691 тоотой хүргүүлсэн.

- Агвааны Уртнасан /кю71102913/-ний гэрлэлтийн нөхөн бүртгэл шалгахад баталгаажсан мэдээлэл архивын цаасан суурьт эх нотлох баримт болон цахим сантай таарч байна. Нөхөн шивэлт гэсэн төлөвтэй бүртгэл нь бүртгэсэн он, сар, өдөр архивын цаасан суурьт эх нотлох баримттай зөрүүтэй байгаа тул уг бүртгэлийг хүчингүй болгохоор хяналтын улсын байцаагчийн 2023 оны 10 дугаар сарын 03 ны өдрийн 5922 тоот дүгнэлтийг Иргэний улсын бүртгэлийн газарт 2023 оны 10 дугаар сарын 10 ны өдрийн 02/691 тоотой хүргүүлж бүртгэл хүчингүй болгосон.
21. Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдлийг бууруулах ажлын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, улсын бүртгэгч нарт бүртгэл хөтлөхөд гарч болзошгүй эрсдлийг бууруулах, мэргэжил арга зүйгээр хангах, тулгарч буй асуудлаар нэгдсэн ойлголт, зөвлөмж чиглэл өгөх зорилгоор 2023 оны 11 дүгээр сарын 02 ны өдөр Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг, Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч нарт Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, Хяналтын улсын байцаагч Д.Наранбилэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч М.Энхтогтох, Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Ариунсайхан нарын бүрэлдэхүүнтэй хэлтсийн сургалтын танхимд сумын 10 улсын бүртгэгчид зоом-ээр, хэлтсийн 15 албан хаагчид танхимаар тус тус сургалт зохион байгуулсан.
22. Иргэний улсын бүртгэлийн “Мэдээллийн сан цэгцлэх” ажлын хүрээнд 829 иргэний архивын цаасан суурьт эх нотлох баримтыг цахимжуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.
23. Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэл, зөвлөмж, үүрэг даалгавар, мэдээ мэдээллийг сумдын улсын бүртгэгчид болон тасгийн улсын бүртгэгч нарт тухай бүр нь хүргэж, онлайн сургалт зохион байгуулж арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.
24. 2023 онд нийт 11631 иргэнд тоон гарын үсэг олголоо.

## **ХОЁР. ИРГЭНИЙ ГЭР БҮЛИЙН БҮРТГЭЛ,ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТАЛААР**

Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагааг явуулахдаа улсын бүртгэлийн ерөнхий хууль, гэр бүлийн тухай хууль, иргэний улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллаа. Иргэний бүртгэлийн мэдээллийн санд дараах бүртгэлүүдийг баталгаажуулсан. Үүнд :

1. Төрсний бүртгэл – 1376
2. Үрчилсний бүртгэл –21
3. Овог,эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл - 109
4. Эцэг /эх/ тогтоосны бүртгэл - 53
5. Гэрлэсний бүртгэл – 324
6. Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл - 104
7. Нас барсны бүртгэл - 354
8. Аймаг дотрох шилжилт хөдөлгөөн -5749
9. Бусад аймаг хотоос шилжин ирсэн – 2526 тус тус бүртгэгдсэн байна.

### **2022 онд бүртгэгдсэн иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг 2023 онд бүртгэсэн бүртгэлтэй харьцуулсан үзүүлэлт**

<b>Он</b>	<b>ИУБ-11</b>	<b>ИУБ-15</b>	<b>ИУБ-16</b>	<b>ИУБ-12</b>	<b>ИУБ-13</b>	<b>ИУБ-14</b>	<b>ИУБ-18</b>
2022 он	1349	321	94	34	94	35	371
2023 он	1376	324	104	21	109	53	354
Өсөлт бууралт	+27	+3	+10	-13	+15	+18	-17

### **2022 онд бүртгэгдсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 2023 онд бүртгэсэн бүртгэлтэй харьцуулсан үзүүлэлт**

Он	Бусад аймаг хотоос шилжин ирсэн	Аймаг дотор шилжин ирсэн
2022 он	2098	4692
2023 он	2526	5749
Өсөлт бууралт	+428	+1057

### **ГУРАВ. ҮНДЭСНИЙ ЭНГИЙН ГАДААД ПАСПОРТ ОЛГОЛТЫН ТАЛААР**

2023 онд 7392 иргэнд шинээр гадаад паспорт олгох хүсэлтийг хүлээн авч гадаадад зорчих эрхийн бүртгэлд бүртгэсэн.

**2022 онд гадаад паспорт, хил орчмын нэг болон олон удаагийн үнэмлэх олголтын байдлыг 2023 онд олгосон олголтын байдалтай харьцуулсан үзүүлэлт**

Он	Гадаад паспорт шинээр	Хил зорчих олон удаагийн үнэмлэх	Хил зорчих нэг удаагийн үнэмлэх
2022 он	1240	0	0
2023 он	7392	27	11
Өсөлт бууралт	+6152	+27	+11

### **ДӨРӨВ. ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ ОЛГОЛТ, АРХИВЫН САНГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ТАЛААР**

2023 онд нийт 3546 иргэний цахим үнэмлэхний захиалга хүлээн авч харъяалалын дагуу сумдын улсын бүртгэгч нарт хүргүүлэн ажилласан.

#### **ТАВ.АРХИВААС ЛАВЛАГАА ОЛГОЛТ**

Иргэний улсын бүртгэлийн архивын сангийн баяжилтанд орсон ИУБ маягтын тоон мэдээллийг сар бүр тогтмол гарган УБЕГазрын Нэгдсэн архивт хүргүүлсэн.

Иргэн, албан байгууллага, хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 4547 лавлагаа гаргаснаас иргэнд 1802, албан байгууллагад 271, албан хэрэгцээнд 2474 лавлагааг тус тус олгосон байна.

ИУБ-11 1376, ИУБ-12 21, ИУБ-13 109, ИУБ-14 53, ИУБ-15 324, ИУБ-16 104, ИУБ-18 354, ИУБ-31 3546 нийт 5887 маягт архивт байрлуулж, архивийн баяжилтыг цаг тухайд нь бүрэн хийж ажилласан.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр давхардсан тоогоор 26482 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.

## **ХУУЛИЙН ЭТГЭЭД, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАСГИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

### **Хуулийн этгээдийн улсын бүртгэл**

2023 онд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдлөг болгон удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, чиглэлийн дагуу иргэн, хуулийн этгээдэд шуурхай үйлчлэн ажилласан. Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 21 ны өдрийн Б/479 тоот тушаалаар Хуулийн этгээдийн улсын бүртгэгчээр Ч.Пүрэвдавга шинээр томилогдон 2 улсын бүртгэгчтэй хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.

#### **Нэг. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ /нийт 3700/:**

- Хуулийн этгээд нэрийн баталгаажуулалт - **716**
- Шинээр үүсгэн байгуулсан хуулийн этгээд – **475**
- Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт - **704**
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгосон - **158**
- Хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа олгосон - **104**
- Хуулийн этгээд татан буулгасан бүртгэл – **7**
- Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулах салбар - **84**
- Хуулийн этгээдэд олгосон тамга, тэмдэгийн хяналтын хуудас - **575**
- Хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг - **99**
- Хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавьсан – **1**

Цахим бүртгэл: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн И-Бизнес цахим сүлжээгээр нийт 777 хүсэлт хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн хуулийн этгээдийн 169 нэр баталгаажуулж, 12 хуулийн этгээдийг шинээр үүсгэн байгуулж, 596 хүсэлтийг бүртгэхээс татгалзсан байна.

#### **Хоёр. Архив, тайлан мэдээ:**

Тайлант хугацаанд улсын бүртгэлд бүртгэсэн нийт 875 бүртгэлийн архивын эх нотлох баримт бичиг, хураан авсан 99 тамга тэмдгийг тус тус дүрэм журмын



дагуу хэлтсийн архивт хүлээлгэн өгч, цаасан баримтыг цахим хэлбэрт шилжүүлэн ажилласан.

Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын даргын 2023 оны 6 дугаар сарын 30 ны өдрийн 9/6417 тоот чиглэлийн дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах, архивлах үйл ажиллагааг нягтлан шалгаж системд архивт шилжүүлсэн төлөвтэй 43 хуулийн этгээдийн мэдээллийг архивын цаасан эх нотлох баримттай тулган архивласан төлөвт шилжүүлэн зөрчлийг арилгасан.

Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 28 ны өдрийн А/1345 тоот тушаал, 2023 оны 08 дугаар сарын 16 ны өдрийн 4/7456 тоот чиглэлийн дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хассан 272 хуулийн этгээдийн хувийн хэргийг тусгаарлан архивласан.

2023 онд хуулийн этгээдийн бүртгэлийн бүх төрлийн үйчилгээний хураамж **53698000** төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. Хуулийн этгээдийн бүртгэлийн хөдөлгөөний тоон мэдээ, архивын мэдээ, үнэт цаасны мэдээ, үйлчилгээний орлогын мэдээг сар бүрийн 25 ны өдрөөр гаргаж УБЕГазрын хуулийн этгээдийн газар, архивын газар, хэлтсийн нягтлан бодогчид тус тус хүргүүлэн ажиллаж байна.

- 2023 оны 05 дугаар сарын 24-ны өдөр Аймгийн Татварын газарт татварын улсын байцаагч нарыг чадваржуулах нэгдсэн сургаланд хуулийн этгээдийн бүртгэлийн хууль, журам, улсын бүртгэлээс хасагдах хуулийн этгээдийн талаар мэдээлэл хийж хамтран ажилласан.

2023 оны 11 дүгээр сарын 02 ны өдөр улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, улсын бүртгэгч нарт бүртгэл хөтлөхөд гарч болзошгүй эрсдэлийг бууруулах, мэргэжил арга зүйгээр хангах, тулгарч буй асуудлаар нэгдсэн ойлголт, зөвлөмж чиглэл өгөх зорилгоор зохион байгуулагдсан сургалтад сумын 10 улсын бүртгэгч, хэлтсийн 15 албан хаагчдад хуулийн этгээдийн улсын бүртгэлийн талаарх мэдээлэл зөвлөгөө өгсөн.

### **ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ**

2023 оны 11 дүгээр сарын байдлаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаандаа Улсын бүртгэлийн хууль, журам болон холбогдох бусад хууль, дүрэм, журмыг мөрдлөг болгон газар, хэлтсийн даргаас өгсөн удирдамж, чиглэлийн дагуу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээдэд хуульд нийцүүлэн шуурхай үйлчлэх зорилготой ажиллаж байна.

## **Нэг. Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг бүртгэж баталгаажуулах**

2023 онд иргэн, хуулийн этгээдээс үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой бүртгэлийн мэдүүлэг 4727, газар өмчлөх эрхтэй холбоотой бүртгэлийн мэдүүлэг 7698 нийт 12425 мэдүүлэг хүлээн авч хянан, холбогдох хууль тогтоомжийн дагуу эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.

Эд хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэлд 2719 иргэний өмчлөх эрхийг баталгаажуулсанаас: Төрөөс үнэгүй хувьчилсан газар өмчлөх эрхийн бүртгэл 1916, Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэл 545, шинээр баригдсан орон сууцны анхны бүртгэлд 254, төрөөс хувьчилсан орон сууцны өмчлөх эрхийг анх удаа бүртгүүлэх 4 хүсэлт хүлээн авч бүртгэсэн.

Гэрээ хэлцэл нийт 7818 бүртгэгдсэнээс: Худалдах, худалдан авах гэрээ 1558, бэлэглэх гэрээ 262, арилжих гэрээ 61, хамтран өмчлөгч өөрчлөгдөх 90, гэрээслэлээр болон өв залгамжлах эрхийн бүртгэл 142, Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл 17, эрх бүхий этгээдийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх 6, Барьцааны гэрээтэй холбоотой бүртгэл 5670, бусад гэрээ 12 тус тус бүртгэсэн.

Эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт залруулгаар 1819 бүртгэл бүртгэсэнээс: Эд хөрөнгийн хаяг, хэмжээ, үнэ, гүйцэтгэл өөрчлөгдөх 1655, Эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх, залруулга 20, үрэгдүүлсэн болон гэмтээсэн гэрчилгээ дахин олгох бүртгэл 86, хувийн хэрэг хаах бүртгэл 58 тус тус бүртгэсэн байна.

**Хоёр. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх мэдээллийн сан болон нотлох баримтаар хувийн хэрэг бүрдүүлж, иргэн, хуулийн этгээд болон хууль хяналтын байгууллагыг лавлагаа, мэдээллээр хангах**

Шүүх, Цагдаа, Прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба болон бусад байгууллагад албан бичгээр эд хөрөнгө өмчлөх эрхтэй холбоотой 239 лавлагаа олгосон. Байгууллагыг төлөөлж эд хөрөнгийн маргаантай бүртгэлээр шүүх хуралд оролцоогүй. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар иргэн, хуулийн этгээдэд 387 лавлагаа олгосон.

Иргэн хуулийн этгээдээс хүлээн авсан эх нотлох баримтуудаар хувийн хэрэг үүсгэж газар өмчлөх эрхийн **19790** хувийн хэрэг, газраас бусад үл хөдлөх хөрөнгийн **10019** хувийн хэрэг, газар эзэмших эрхийн **4677** хувийн хэрэг, газар ашиглах эрхийн **140** хувийн хэрэг нийт **34626** хувийн хэрэг цаасан хэлбэрээр архивт хадгалдагдаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжаар нийт 140.693.968 төгрөгийг улсын төсөвт, тэмдэгтийн хураамжаар 15.497.627 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого 658.226.688 төгрөгийг орон нутгийн төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

### **Гурав. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны бодлого төлөвлөлтийн хүрээнд**

- УБЕГ-ын ЭХЭУБ-ын газрын 2023.01.10-ны өдрийн 6/277 тоот хугацаатай үүрэг өгөх тухай албан бичиг, хавсралтыг хүлээн авч Өмнөговь аймагт хамаарах 9 бүртгэлийг нягтлан шалгаж зөрүүтэй хэмжээг Хяналтын улсын байцаагчийн 1500 дугаартай дүгнэлтийг үндэслэн залруулж илтгэх хуудас хавсралтын хамт ЭХЭУБ-ын газарт хугацаанд нь хүрүүлсэн.
- УБЕГ-ын ЭХЭУБ-ын газрын 2023.03.02-ны өдрийн 5/1854 тоот чиглэлээр Өмнөговь аймагт хамаарах өмчлөгчийн төлөв өөрчлөгдөөгүй “Хувийн хэрэг хаах” 53 бүртгэлийг нягтлан шалгаж Хяналтын улсын байцаагчийн 1500 дугаартай дүгнэлтийг үндэслэн засварлаж илтгэх хуудас хавсралтын хамт ЭХЭУБ-ын газарт хугацаанд нь хүргүүлсэн.
- ЭХЭУБ-ын газраас 2023.04.12-ны өдөр зохион байгуулсан онлайн сургалтанд бүрэн хамрагдаж өгсөн чиглэл зөвлөмжийг өдөр тутмын ажил үйлчилгээнд мөрдөн ажиллаж байна.
- УБЕГ-ын ЭХЭУБ-ын газрын 2023.05.01-ны өдрийн 5/4053 тоот чиглэлээр мэдээллийн санд газрын зориулалт буруу бүртгэгдсэн 4303 бүртгэлийг нягтлан шалгаж Хяналтын улсын байцаагчийн 1500 дугаартай дүгнэлтийг үндэслэн засварлаж илтгэх хуудас, засварласан хавсралтын хамт ЭХЭУБ-ын газарт хугацаанд нь хүргүүлсэн.
- УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын 2023.05.15-ны өдрийн 5/4618 тоот үүрэг даалгавар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан /ePRS/-д нэгж талбарын дугаар оруулаагүй Өмнөговь аймагт хамаарах 4449 бүртгэлийн жагсаалтыг татан авч сум сумаар нь улсын бүртгэгч нарт хувиарлан, хувийн хэрэг, нотлох баримтыг нягтлан шалгаж нэгж талбарын дугаарыг жагсаалтад тусгав.
- 2023.05.16-ны өдрийн 03/360 тоот албан бичгээр аймгийн ГХБХБГазарт 2010 оноос өмнө ашиглалтад орж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд нэгж талбарын дугааргүй бүртгэгдсэн нийтийн орон сууцны жагсаалтыг хүргүүлэн нэгж талбарын дугаарыг олгосон.

- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн цахим сан /ePRS/-д нэгж талбарын дугаар оруулаагүй Өмнөговь аймагт хамаарах 4428 бүртгэлд хяналтын улсын байцаагчийн 2022 оны 1500 тоот дүгнэлтийг үндэслэн нэгж талбарын дугаарыг нөхөж оруулсан.
- Сумдын улсын бүртгэгч нараас ЭХЭУБүртгэлийн анхны бүртгэлийн 61 бүртгэлийн мэдүүлэг хүлээн авч бүртгэн бичигдсэн гэрчилгээг бүртгэгч нарт хүргүүлэн иргэдэд олгосон.
- Даланзадгад суманд 9,10 дугаар баг шинээр байгуулагдаж байгаатай холбоотой ажлын хэсгийн гишүүдэд 1,6 дугаар багт бүртгэлтэй өмчлөлийн газар болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн судалгааг гарган өгч 2 удаа мэдээлэл хийсэн.
- Аймгийн Татварын газар 2023.05.24-ны өдөр татварын улсын байцаагч нарыг чадваржуулах нэгдсэн сургалт зохион байгуулж ЭХЭУБүртгэлийн хууль, журмын талаар мэдээлэл хийж хамтран ажилласан.
- 2023 оны 1,2 дугаар улиралд Ханбогд сумын улсын бүртгэгч У.Цэенням 18 байгууллагын 459 иргэнд ЭХЭУБүртгэлийн хууль тогтоомж, бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой мэдээлэл сургалт зохион байгуулсан.
- УБЕГазрын ЭХЭУБүртгэлийн газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 26 ны өдрийн 5/9855 тоот чиглэл, 2023 оны 11 дүгээр сарын 06 ны өдрийн 5/10279 тоот чиглэлийн дагуу нийт 72 шинээр баригдсан нийтийн орон сууц, авто зогсоол, үйлчилгээ, бусад зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийн захиалагч, хөрөнгө оруулагч, худалдан авагчийн нэрсийн жагсаалт, түүнд хавсарган ирүүлсэн холбогдох нотлох баримтуудыг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн системд нягтлан шалгаж 65 Ж дугаар олгон цахимжуулах ажлыг 90,3% хийж гүйцэтгэсэн.

#### **4. ПРОГРАМ ХАНГАМЖИЙН ТАЛААР**

Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээллийн технологийн ажилтан нь “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”, Монгол Улсын Засгийн газраас баталсан “Мэдээлэл, сүлжээний аюулгүй байдлыг хангах” журмыг удирдлага болгон Мэдээлэл технологийн чиглэлээр 2023 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Иргэдэд үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалт болон шинэчлэгдсэн баримт бичгүүдийг цахимд ойлгогдохуйц байдлаар байршуулсан.

Цахим хуудаст байгууллагын үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг цаг тухай бүрт нь байршуулсан ба эхний хагас жилийн байдлаар цаг үе,

үйл явдлын талаарх мэдээ 36, иргэд, аж ахуй нэгжүүдэд заавар зөвлөгөө өгсөн талаар бичлэг 5, иргэд аж ахуй нэгжүүдэд заавар зөвлөгөө өгсөн мэдээлэл 10-г байгууллагын албан ёсны цахим хуудас болох [www.umnugovi.burtgel.gov.mn](http://www.umnugovi.burtgel.gov.mn) хаяг болон Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс facebook page-д байршуулан ажиллаж байна.

Ажлын сул орон тооны зарыг цахим хуудсанд байршуулан зарын групп хуудсанд нийтлэн олон нийтэд нээлттэй зарлан ажилласан.

Улсын бүртгэлийн хэлтсийн үйлчилгээний зааланд байрлах КИОСК машинд image file уншуулан, иргэн цахим гарын үсгээ КИОСК машинаар авах бололцоог бүрдүүлэн ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас хүргүүлсэн зөвлөмжийн дагуу цахим хуудсын ажиллагааг тогтворжуулж цаг үе, үйл явдлын мэдээг тухай бүрт нь байршуулж иргэдэд мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэх ажлыг хийж гүйцэтгэж байна.

Хэлтсийн албан хаагчдын компьютер, тоног төхөөрөмжүүдийг эвдрэл гэмтэл гарсан үед цаг алдалгүй тухай бүрт нь засварлаж хэвийн ажиллагаанд ажиллуулж байна.

Байгууллагын дотоод сүлжээний ажиллах хэвийн байдлыг бүрдүүлэн сүлжээнд алдаа гарах, тасрах гэх мэт техникийн саатлуудыг тухай бүрт нь холбогдох арга хэмжээг аван ажиллаж байна.

2023 онд Улсын бүртгэлийн ерөнхий газраас цахим видео хурал, болон сургалтууд 10 гаруй удаа хийгдэж цахим хурлыг тухай бүрт нь холбон техник төхөөрөмжийг хэвийн ажиллуулсан. Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь сумын улсын бүртгэгч нартай цахим видео хурал болон сургалтыг 5 удаа амжилттай холбон ажилласан.

“Цаг бүртгэлийн программ”- г албан хаагчдын нүүрийг таньж бүртгэдэг болгож шинэчилсэн.

Байгууллагын сүлжээний аюулгүй байдал, гадны халдлага, мэдээлэл алдагдхаас сэргийлэн арга хэмжээ авч ажиллан Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн заавар зөвлөмжийн дагуу сүлжээний хамгаалалтыг сайжруулж тохиргоог хийн ажиллаж байна.

### **Ил тод байдлын чиглэлээр**

Байгууллагын хийж гүйцэтгэсэн ажил, иргэдэд мэдээллэх шаардлагатай мэдээг цаг тухай бүрт нь байршуулсан ба 5 мэдээ мэдээллийг самбарт хэвлэн байршуулсан мөн иргэдэд мэдээллэх шаардлагатай мэдээг цаг тухай бүрт нь байршуулсан ба цахим хуудас болон [facebook](#) хуудсанд 36 мэдээ тухай бүр тавигдсан байна.

Өргөдөл, гомдол хүлээн авах хариуцсан албан хаагчийн албан тушаал, овог нэр, харилцах утасны дугаар тодорхой бичиж цахимд байршуулсан.

Сул орон тооны зарыг нийтэд зарлах, цахим болон мэдээллийн самбарт иргэдэд харагдахуйц байршуулсан ба нийт 8 сул орон тооны зарыг байршуулан ажиллаж байна.

### **Бусад ажлын чиглэлээр**

Байгууллагын эвдэрч засах шаардлагатай эд зүйлсийг тухай бүрт засаж янзалж хэвийн болгосон. Байгууллагын серверийн өрөөн доторх эд зүйлсийг цэгцэлж, ашиглагдах боложгүй болсон эд зүйлсийг устгалд оруулсан.

Байгууллагаас зохион байгуулж байгаа хамт олны ажилд идэвх санаачлагатай оролцон ажиллаж байна.

Няравын ажил үүргийг давхар эрхэлж байгаа тул сар бүрийн үнэт цаасны мэдээг нэгтгэж, шаардлагатай үнэт цаасыг захиалах, бичиг хэргийн холбогдолтой зүйлсийг цуглуулах, үнэт цаас хувиарлах ажлуудыг хийсэн.

Мөн удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг цаг тухай бүрт нь хийж гүйцэтгэж байна.

## **5. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР**

Хяналтын улсын байцаагч нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журам, Зөрчлийн тухай хууль, болон бусад холбогдох хууль, журмын хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлтсийн даргаар баталгаажуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна

Байнгын хяналтыг Иргэний улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Архив, Мэдээллийн технологийн аюулгүй байдлын чиглэлээр хийсэн.

**ИУБүртгэл:** Зөрчлийн тухай хуулийн 15.24.1, 15.24.4, 15.23.1.1. 10.20.1 дүгээр зүйлийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг нийт 249 иргэн, хуулийн этгээдэд нийт 16 690 000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. Үүнээс:

- Иргэний үнэмлэх сунгалтын хугацаа хэтрүүлсэн 341 иргэнийг 6 820 000 төгрөгөөр,
  - Иргэний цахим үнэмлэх үрэгдүүлсэн 129 иргэнийг 3 870 000 төгрөг,
  - Хуулийн этгээдийн тамга тэмдэгээ үрэгдүүлсэн 5 компанийг 2 500 000 төгрөгөөр,
- Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтөө хуулийн хугацаанд бүртгүүлээгүй 7 хуулийн этгээдийг 3 500 000 төгрөгөөр тус тус торгож, тухай бүрт нь аймгийн Хяналтын прокурор Г.Ганбаярт хянуулж холбогдох зөвлөгөө мэдээллийг авч, хамтран ажилласан. Мөн шийтгэлийн хуудасны зарцуулалтын тайланг сар бүр гаргаж, ахлах нягтлан бодогчид хүлээлгэн өгсөн.

Иргэний баримт бичгийн зөрчилтэй 25 иргэний өгөдөлийг хүлээн авч\_мэдээллийг нягтлан шалгаж, дүгнэлтийг УБЕГазрын Хяналт, шалгалтын газарт хүргүүлж, бүрэн шийдвэрлэсэн. Хяналтын улсын байцаагчийн хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу хөдөөгийн 11 сумын 2022 онд бүртгэсэн иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэлийн нийт 3609 материалд хяналт, шалгаж иргэний цахим үнэмлэхний хүчинтэй хугацааг нягтлан шалгах, өргөдлийн огноо, толгойг зөв бичүүлж байх талаар улсын бүртгэгч нарт 2023 оны 04 дүгээр сарын 10-нд зөвлөмж хүргүүлсэн. Тайлант хугацаанд шилжилт хөдөлгөөний бүртгэл, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэлийн бүрдүүлбэр материалын нийт 6114 бүртгэлд хяналт шалгалт хийсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газры 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 3684/6 тоот чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн хүрээнд Өмнөговь аймгийн 15 сумын 2023.01.02-2023.04.19-н ийг дуустал хугацаанд бүртгэгдсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийн журналыг бүртгэгч тус бүрээс цахим хэлбэрээр авч нийт 899 бүртгэлийн материалыг иргэний улсын бүртгэлийн

мэдээллийн сан, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сан/ePRS/-д нягтлан шалгасан хуулийн хугацаанд үнэн зөв шивж, баталгаажуулсанд хяналт тавиж, илтгэх хуудсыг Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн.

Тайлант хугацаанд шилжилт хөдөлгөөний бүртгэл, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэлийн бүрдүүлбэр материалын нийт 7328 бүртгэлд хяналт шалгалт хийхэд зөчил дутагдал илрээгүй.

**ХЭУБүртгэл:** Хуулийн этгээдийн оноосон нэрийн бүртгэл, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ERS програмд хандах эрхийн дагуу орж бүртгэлүүдийг өдөр тутам хянаж байна. Иргэн Б.Болормаагаас хуулийн этгээдийн улсын бүртгэгч М.Энхтогтохын 2021 оны 01 дүгээр сарын 26, 29-ний өдөр бүртгэсэн “Мөнх түшиг транс” /3632709/ ХХКомпаний бүртгэлтэй холбогдох бичгээр гаргасан гомдлыг хүлээн авч шалган, хариу тайлбарыг хүргүүлсэн.

Тайлангийн хугацаанд шинээр үүсгэн байгуулагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон нийт 479 бүртгэлийн бүрдүүлбэр материалын архивын хувийн хэрэг дэх эх нотлох баримтыг татан авч шалгахад зөрчил дутагдал илрээгүй, бүгд бүртгэлийн бүрдүүлбэр хангасан нотлох баримтууд байсан.

Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтөө хуулийн хугацаанд бүртгүүлээгүй Зөрчлийн тухай хуулийн 15.23.1.1 дэх хэсэгт зааснаар торгуулийн арга хэмжээ авагдсан "Өмнөговь аймгийн Төрийн үйлчилгээний алба"УТҮГ, "Монголын төмөр зам"ТӨХК, "Ханбогд вейст менежмент центр"ХХК, "Өмнөговь аймгийн Ханбогд сумын 21-р цэцэрлэг"УТҮГазар, "Авто тээврийн үндэсний төв", "Ханбогд хөгжлийн хурдасгуур оюу толгой сан", "Оргилдорж шүг"ОНӨААТҮГ мөн хуулийн этгээдийн тамга тэмдгээ хаяж үрэгдүүлсэн "Говь ориент"ХХК, "Шанх транс"ХХК, "Халхын хийморь"ХХК, "Тэгш дүүрэн төгөлдөр"ХХК, "Дал хуудас"ХХК-г зөрчлийн тухай хуулийн 10.20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 500 нэгжээр торгон, хуучин хяналтын дугаарыг хүчингүй болгосон дүгнэлтийг тус тус үйлдэж Хяналт шалгалтын газарт хүргүүлэн зөрчлийг бүрэн арилгасан.

**ЭХЭУБүртгэл:** ЭХЭУБүртгэлийн ePRS програмд хандах эрхийн дагуу орж бүртгэлийн бүрдүүлбэр материалуудыг түүвэрчлэн шалгаж байна. Тайлангийн хугацаанд газар өмчлөх эрхийн бүртгэл, барьцаат зээлийн гэрээ, БЗГэрээ дуусгавар болгосон, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэлийн нийт 1518 бүртгэлийн бүрдүүлбэр материалыг шалгахад ямар нэгэн зөрчил дутагдал



илрээгүй. ЭХЭУБүртгэлийн эрх авсан Цогтцэций, Ханбогд, Гурвантэс, Манлай сумын улсын бүртгэгч нарын ирүүлсэн бүрдүүлбэр материалуудыг тухай бүр шалгаж, илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулан, холбогдох зөвлөгөөг өгч ажилласан.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой нийт 81 дүгнэлтийг Хяналт шалгалтын газарт хүргүүлж, хяналт шалгалт, зөрчлийн нэгдсэн санд баталгаажиж бүрэн шийдвэрлэсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 39 дүгнэлт үйлдэж, Хяналт шалгалтын газарт хүргүүлж, бүрэн шийдвэрлэсэн.

### **Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны жилийн эцсийн тайлан гаргасан**

---

1. Ч.Энхмөнх - Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
2. Д.Наранбилэг - Хяналтын улсын байцаагч
3. С.Ариунсайхан - ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч
4. М.Энхтогтох - ХЭ,ЭХЭУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч
5. З.Хасар - Улсын бүртгэгч
6. Ч.Пүрэвдавга - Улсын бүртгэгч
6. С.Мөнхбаяр - Улсын бүртгэгч
7. Т.Нямсамбуу - Улсын бүртгэгч
8. М.Оюун-Эрдэнэ - Улсын бүртгэгч
9. Б.Баясгалан - Улсын бүртгэгч
10. С.Батхүү - Ахлах нягтлан бодогч
11. А.Цэцэгдэлгэр - ИБТасгийн архивч
12. А.Цэцэгжаргал - ЭХЭБТасгийн архивч
13. Х.Хулан - Мэдээллийн технологийн ажилтан, нярав
14. О.Жижигчулуун - Бичиг хэргийн эрхлэгч
16. Сумын 12 улсын бүртгэгч

